

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛИЙН
ХОРООНЫ 2016 ОНЫ АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН**

2017.02.15

Иргэний хөдөлмөрлөх эрх, түүнтэй холбоотой өргөн асуудлуудыг шийдвэрлэхэд санал оруулах, хөдөлмөрлөх явцад ажлын орчин нөхцлийг дээшлүүлэх, нийгмийн асуудлаа (цалин хөлс нэмэгдүүлэх, тэтгэмж дэмжлэг үзүүлэх бусад) шийдвэрлэхэд нь ажил олгогч болон холбогдох газруудад уламжлах, шийдвэрлүүлэхэд гол зорилтоо болгосон иргэдийн дуу хоолойг бодлого боловсруулагчид, ажил олгогчид хүргэж байдаг ажилдын эрх ашгийг хамгаалсан төрийн бус байгууллага бол Үйлдвэрчний эвлэлийн хороод байдаг.

Энэ ч утгаараа байгууллагуудын үйлдвэрчний эвлэлүүдийн холбоодууд нэгдэж иргэн та бүхний эрхийг хамгаалан цалин хөлс нэмэгдүүлэх, хуулиудад нэмэлт өөрчлөлтийг оруулах, нийгмийн асуудлаа шийдвэрлүүлэх талаар тэмцэж үр дүнд хүрч байсан нь олонтой.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Үйлдвэрчний эвлэлийн хороо нь Засаг даргын Тамгын газрын нийт ажилчдын хуралдаанаар байгууллагын үйлдвэрчний эвлэлийн хорооны тэргүүлэгч, даргаа сонгож үйл ажиллагаагаа шинэ бүрэлдэхүүнтэйгээр эхлүүлснээс хойш 2 жил гаруйн хугацаа өнгөрч, хамтын гэрээг шинээр байгуулан баталгаажуулж ажиллаж байна.

Энэ хугацаанд аймгийн Засаг даргын Үйлдвэрчний эвлэлийн хороо нь нийт ажилчдынхаа сэтгэлд нийцсэн арга хэмжээг зохион байгуулах, хамт олон болон байгууллагаас зохион байгуулагдаж буй ажил, үйл ажиллагаанд Үйлдвэрчнийхээ эвлэлийн гишүүдийн нэрийн өмнөөс тодорхой санхүүжилт үзүүлж хамтарч ажиллах, тэдний санал, сэтгэгдлийн мөрөөр тодорхой ажлуудыг хийж, холбогдох удирдлагуудад танилцуулж ажилтан, албан хаагчдынхаа эрх ашгийг нь хамгаалах, зохион байгуулж буй ажил, санхүүгийн орлого, зарлагаа Засаг даргын Тамгын газрын веб хуудсанд тогтмол байршуулан, хамт олондоо ил тод нээлттэй хүргэх талаар анхаарч ажиллаж ирлээ.

2016 онд аймгийн Засаг даргын Үйлдвэрчний эвлэлийн гишүүдийн татвараас нийт **8.347.771.00** мянган төгрөг (**Найман сая гурван зуун дөчин долоон мянга долоон зуун далан нэгэн төгрөг**)-ийн орлого бүрдсэн байна.

Хүснэгт 1. 2016 оны гишүүдийн татварын орлогын дүн

| Он сар өдөр | Орлогын нэр | Орлогын хэмжээ (мян төг) |
|---------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------|--------------------------|
| 2015 оны жилийн эцсийн үлдээгдэл | | 37.875.00 |
| 2016.02.03 | Тамгын газрын үйлдвэрчний эвлэлийн гишүүдийн татвар | 360.540.00 |
| 2016.03.25 | Тамгын газрын үйлдвэрчний эвлэлийн гишүүдийн дугаар сарын татвар | 758.984.00 |
| 2016.03.25 | Нийтлэг үйлчилгээний албаны үйлдвэрчний эвлэлийн гишүүдийн сарын татвар (НҮА) | 43.836.00 |
| 2016.04.29 | Тамгын газрын үйлдвэрчний эвлэлийн гишүүдийн татвар (НҮА) | 14.755.00 |
| 2016.04.29 | Тамгын газрын үйлдвэрчний эвлэлийн гишүүдийн татвар | 366.936.00 |
| 2016.05.27 | Тамгын газрын үйлдвэрчний эвлэлийн гишүүдийн татвар | 381.296.00 |
| 2016.06.28 | Тамгын газрын үйлдвэрчний эвлэлийн гишүүдийн татвар (НҮА) | 26.685.00 |
| 2016..06.28 | Тамгын газрын үйлдвэрчний эвлэлийн гишүүдийн татвар | 377.332.00 |
| 2016.07.29 | Үйлдвэрчний эвлэлийн гишүүдийн татвар | 435.506.00 |
| 2016.10.04 | С.Доржоос орлого | 30.000.00 |
| 2016.11.15 | Нийтлэг үйлчилгээний албаны үйлдвэрчний эвлэлийн гишүүдийн татвар | 1.408.693.00 |
| 2016.11.23 | Тамгын газрын үйлдвэрчний эвлэлийн гишүүдийн сарын татвар | 399.525.00 |
| 2016.12.19 | Тамгын газрын үйлдвэрчний эвлэлийн гишүүдийн татвар | 400.000,00 |
| 2016.12.22 | Тамгын газрын үйлдвэрчний эвлэлийн татвар | 939.829.00 |
| 2016.12.27 | Тамгын газрын үйлдвэрчний эвлэлийн татвар (Буцаан олголт) | 2.365.979.00 |
| ДҮН (Найман сая гурван зуун дөчин долоон мянга долоон зуун далан нэгэн төгрөг) | | 8.347.771.00 |

Дээрхи орлогыг зарцуулахдаа байгууллагын Үйлдвэрчний эвлэлийн хорооны тэргүүлэгч гишүүдийн саналыг ямагт тусган ажилласан ба сонгуулийн жил болж зарим тэргүүлэгчид ажлаа өөрчлөх болсноор хуучин ажлын байранд томилогдсон удирдлагыг тэргүүлэгчээр ажиллуулж, татварын орлогоо үр дүнтэй, зүй зохистой зарцуулахад анхаарч ажилласнаар 2016 оны 12 сарын 28-

ны байдлаар дансандаа 1.780.971.00 төгрөг (нэг сая долоон зуун наян мянга есөн зуун далан нэгэн)-ийн үлдэгдэлтэй байна.

2016 оны аймгийн Засаг даргын Тамгын газрын Үйлдвэрчний эвлэлийн холбооны гишүүдийн татварын орлогын зарцуулалтыг дэлгэрэнгүйгээр танилцуулахад:

Хүснэгт 2. 2016 оны гишүүдийн татварын зарцуулалтын дүн

| Он сар өдөр | Татварын зарлага | Зориулалт |
|-------------|---------------------|----------------------------------------------------------------------------------------|
| 2016.02.04 | 200.000.00 | Дэмжлэг (эмэгтэйчүүдийн тэмцээний биеийн тамирын хувцас) |
| 2016.02.20 | 250.000.00 | П.Цэцэгсүрэнд өрөө тасалгаа галд өртөж, өр төлбөр үүссэн |
| 2016.03.01 | 970.000.00 | Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийн өдөр, Монгол цэргийн баярын тэмцээний зардал |
| 2016.03.10 | 280.000.00 | Байгууллагын тамирчдын аймгийн аваргад оролцох тэмцээний бооцоо (шилжүүлгээр) |
| 2016.03.25 | 140.000.00 | Үйлдвэрчний эвлэлүүдийн хорооны онол практикийн хурал (шилжүүлгээр) |
| 2016.03.28 | 300.000.00 | Даргёрханд эмчилгээний дэмжлэг |
| 2016.05.05 | 130.000.00 | Үйлчлэгч Баасандуламд эмчилгээний дэмжлэг |
| 2016.05.13 | 500.000.00 | Аймгийн үйлдвэрчний эвлэлүүдийн холбоонд татвар төлөв |
| 2016.05.13 | 112.500.00 | Мод тарих өдөр (Ажилчдын салхинд гарах) |
| 2016. 05.24 | 400.000.00 | Хуримтлалын дансанд шилжүүлэв |
| 2016.07.16 | 385.400.00 | АСЕАН чуулга уулзалтанд оролцох замын зардал хурал (шилжүүлгээр) |
| 2016.08.03 | 200.000.00 | Ажилчдын урьдчилан сэргийлэх үзлэгийн төлбөр нөхөн төлөв |
| 2016.09.14 | 700.000.00 | Аймгийн үйлдвэрчний эвлэлүүдийн холбоонд татвар төлөв |
| 2016.10.04 | 190.000.00 | 2016 оны урамшуулал |
| 2016. 12.02 | 253.900.00 | Говь-Алтай аймгийн ҮЭ-ийн бүсийн сургалтын нэг талын машины бензиний зардал |
| 2016.12.28 | 195.000.00 | Шилдэг тэргүүний үйлдвэрчний эвлэлийн гишүүдийн шагнал (шинэ жилээр) |
| 2016.12.28 | 1.350.000.00 | Байгууллагын шинэ жилийн арга хэмжээний зардал |
| | 6.566.800.00. | 2016 оны нийт зарлага |
| | 1.780.971.00 | 2016 оны үлдэгдэл (нэг сая долоон зуун наян мянга есөн зуун далан нэгэн төгрөг) |

2016 онд байгууллагын Үйлдвэрчний эвэлийн хорооноос зохион байгуулсан дээрх арга хэмжээг хувилж үзэхэд 2016 оны гишүүдийн татварын орлогын 2.4 сая буюу 29.1 хувийг байгууллагын хамт олны нийтээр зохион байгуулсан тэмдэглэлт арга хэмжээнд, 1.2 сая буюу 14.4 хувийг аймгийн Үйлдвэрчний эвлэлүүдийн холбооны татварт, 0.8 сая буюу 9.9 хувийг байгууллагын албан хаагч, ажилтнууд, баг хамт олонд дэмжлэг үзүүлэхэд, 0.7 сая буюу 9.3 хувийг хурал чуулган, (АСЕАН-ны чуулган, онол практикийн хурал) зөвлөгөөн, сургалт семинарт, 0.5 сая буюу 5.7 хувийг байгууллагаас оролцсон тэмцээн уралдаан бусад арга хэмжээнд тус тус зарцуулсан байна.

Тус онд Улсын Их Хурлын болон орон нутгийн сонгууль болсонтой холбоотойгоор Тамгын газрын бүтэц орон тоонд зарим өөрчлөлт орж, ажлаас чөлөөлөгдсөн, үндэслэлгүй халагдсан, ажилчдын цалинг үндэслэлгүйгээр хасаж олгосон зэрэг байгууллагын ажилчдын эрх ашигтай холбоотой санал, гомдол ирсний дагуу дүгнэлт хийж ажил олгогчтой аман байдлаар болон албан тоотоор харьцаж зөвшилцөх, цаашид энэ талаар ажилчдыг хохироохгүй байх талаар албан тоот хүргүүлж ажиллаа.

Мөн байгууллагын ажилчдын нийгмийн баталгааг хангах, өмнө батлагдсан дотоод журмын хэрэгжилт хангалтгүй, зарим заалт тухайлбал ажлын цагийн бүртгэлийг баримтлан цалин үндэслэлгүйгээр хасч олгож байгаа талаар ажилчдын мэдүүлсэн саналыг үндэслэж байгууллагын дотоод журмыг өөрчлөх талаар санал хүргүүлж, Нийгмийн бодлогын хэлтэс хариуцан хэлтэс болон ажилчдаас саналыг авч нэгтгэн шинэчлэн боловсруулж бүх нийтийн хурлаараа хэлэлцүүлэн шинэчилж батлууллаа.

Ингэснээр байгууллагын дотоод журмын хэрэгжилт бодитой, үндэслэлтэй болж хэрэгжилт нь сайжрах, бүх нийтээрээ дагаж мөрдөж боломж бүрдлээ.

Тус онд ажилчдын идэвхитэй амралт зохион байгуулах, хөдөлгөөнийг эрхэмлэн нийтийн биеийн тамирыг сурталчлах, ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах, байгууллага хамт олны дотроос эрүүл мэндийн эмчилгээ хийлгэхээр явсан хүмүүст дэмжлэг үзүүлэх, байгууллагын нэрийн өмнөөс уралдаан тэмцээнд оролцож буй баг тамирчдад туслах, бүх нийтээр тэмдэглэх баярын өдрүүдэд тодорхой санхүүжилтийг олгож хамт олны чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх арга хэмжээг зохион байгуулах, үйлдвэрчний эвлэлийн

гишүүнийхээ нэрийг өндөрт өргөж ажлын амжилт гаргасан тэргүүний гишүүдээ шинэ жилээр урамшуулах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж ажиллаа.

2016 оны 3 сард байгууллагын Үйлдвэрчний эвлэлийн хорооноос уламжлал болгон зохион байгуулдаг Монгол цэргийн баяр, эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан хэлэс хоорондын дунд спортын 4 төрлөөр 8 багийн нөхөрсөг тэмцээнийг зохион байгуулж, нийтлэг үйлчилгээний I баг тэргүүлж байгууллагын үйлдвэрчний эвлэлийн хорооны шилжин явах цом гардлаа.

2016 оны 4 сард байгууллагын ажилчын эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийг хэлтэс бүрээс саналыг авч нэгтгэн 51 хүнийг үзлэгт хамруулж эмчийн зөвлөгөө, зааварыг өгүүлж, шаардлагатай зарим хүнийг дараагийн шатлалын оношилгоонд хамрууллаа.

Мөн 2016 оны 7 сарын эхээр Улаанбаатар хотноо Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас санаачлан зохион байгуулсан “Нийгмийн хамгааллын суурь хэм хэмжээ” чуулган, “Нийгмийн түншлэлийн харилцааг боловсронгуй болгох нь” хэлэлцүүлэгт аймгийн төлөөлөлд багтан оролцож олон улсын туршлагаас суралцаж, “Хөдөлмөрийн хүний эрх ашгийг хамгаалах, түүний нийгмийн үр нөлөө” сэдэвчилсэн хуралдаанд Ховд аймгийг төлөөлөн танилцуулга, мэдээлэл бэлтгэж оролцох зэрэг хамт олонд чиглэсэн томоохон арга хэмжээг хэрэгжүүллээ.

Мөн байгууллагын Үйлдвэрчний эвлэлийн хороонд ирүүлсэн өргөдөл, хүсэлтийн дагуу шаардлагатай дэмжлэгүүдийг үзүүлж, ажилласныг та бүхэн орлогын зарцуулалтын тооцооноос танилцахыг хүсэж байна.

Цаашид аймгийн Засаг даргын Тамгын газрын Үйлдвэрчний эвлэлийн хороо нь аймгийн Үйлдвэрчний эвлэлүүдийн холбооны 100 жилийн ойг угтсан төлөвлөгөө боловсруулан ажиллаж, үйлдвэрчний эвлэлийн гишүүдийн үүрэг, тэдний бүтээлч ажлыг иргэд олон нийтэд сурталчлан таниулах, ой угтсан туг аялуулах, уламжлалт арга хэмжээгээ өндөр хэмжээнд зохион байгуулах, гишүүдийнхээ ирүүлсэн санал, өргөдлийг шуурхай шийдвэрлэхэд ажлаа чиглүүлэх болно.